

**“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ,
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭР, ЗАМ, ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ, ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ТУШААЛЫН ХЭРЭГЖИЛТ, ШИЛЭН
ДАНСНЫ ХӨТЛӨЛТИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН ТОВЧ ТАЙЛАН**

2023.09.18

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагааны хэрэгжилтэд 2023 оны III дугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах зарим асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах, удирдлагуудыг холбогдох мэдээ, мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалыг тус тус үндэслэв.

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагаанд 2023 оны III улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалын хэрэгжилт, ТНДБ-ын тушаалын хэрэгжилт, шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ гэсэн 6 үзүүлэлтээр 74 арга хэмжээг дүгнэж 2023 оны III улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нэгдсэн дүнгээр **95,3** хувьтай байна.

Гурав. Үнэлэлт.

3.1 Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний III улирлын хэрэгжилт 86,05 хувьтай бөгөөд 38 ажлын хэрэгжилтийг доорх хүснэгтэд үзүүлэв.

| Нийт заалт | Үүнээс (хувиар) | | | | | | | Хугацаа болоогүй | Хэрэгжилтийн дундаж хувь |
|------------|-----------------|----|----|----|----|---|---|------------------|--------------------------|
| | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | | | |
| 38 | 15 | 10 | 11 | 2 | - | - | - | 86,05% | |

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс 50 хувиар үнэлэгдсэн дараах 2 арга хэмжээ байна.

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувийн үнэлгээтэй 2 арга хэмжээ:

I. Арга хэмжээ: 1,1. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 5.0 сая.тн /2,4/ сая.тн ачаа тээвэрлэнэ.

Зорилтот түвшин: III улирал: гүйцэтгэл 70 хувьд хүргэнэ.

Хэрэгжилт: 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар нийт 1,181,782.54 тонн ачаа тээвэрлэж эхний 3 улирлын байдлаар төлөвлөгөөний биелэлт 23.63 хувийн биелэлттэй байна. Тээвэрлэлтийн чиглэлээр нь авч үзвэл Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 358,508.63 тонн ачаа тээвэрлэж 11,71 хувь, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 823,273.91 тонн ачаа тээвэрлэж, тус чиглэлийн төлөвлөгөөний биелэлт 42,47 хувь байна. Тээвэрлэсэн ачааны төрлөөр нь авч үзвэл:

Экспортын чингэлэгтэй нүүрс боомтоор:

- Гашуунсухайт боомтоор-329,852 тонн
- Бусад (МТЛ) боомтоор -494,162 тонн

Дотоодын эрчим хүчний нүүрс тээвэр /мидлинг/:

- Тавантолгой түлш ХХК-239,658 тонн
- Цемент шохой ТӨХК-6,461 тонн

Нефтийн бүтээгдэхүүн:

Шунхлай ХХК- 41,203 тонн

II Арга хэмжээ: 2.4. Гашуунсухайт-Ганцмод боомтын 7.9 км төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх.

Зорилтот түвшин: I-III улирал: ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг 100 хувьд хүргэнэ

Хэрэгжилт: Техник, эдийн засгийн үндэслэлийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хянан, мөн оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх төмөр зам, далайн тээврийн салбарын Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлөөс зарчмын хувьд дэмжин нийт 42 санал, зөвлөмжийг ирүүлсний дагуу ажлын явц 70 хувь, мөн зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 04/3862 дугаартай албан бичгээр нийт 35 санал, зөвлөмж ирүүлсний дагуу ажлын явц 50 хувийн гүйцэтгэлтэй байна.

БНХАУ-ын Үндэсний төмөр замын газраас Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрэн байгууламжийг хамтран барих Засгийн газрын хоорондын хэлэлцээр байгуулах зорилгоор шинээр байгуулагдах гэж буй ажлын хэсэгт “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн зүгээс орж ажиллах албан тушаалтны нэрсийг 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 1/1734 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна.

3.2 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

| Нийт заалт | Үүнээс (хувиар) | | | | | | Хэрэгжилтийн дундаж хувь |
|------------|-----------------|----|----|----|----|---|--------------------------|
| | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | |
| 1 | 1 | - | - | - | - | - | 100 |

ЗГҮАМХ-ийн 3.6.3. Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ

Шаардлагатай материалын нөөц бүрдүүлэлт, замын дээд бүтцийн материалын нөөцийг төлөвлөсөн хэмжээнд бүрэн бүрдүүлж нөөцөлсөн байна.Үүнд:

1. Тавантолгой өртөөний барилга байгууламжуудын цогцолборыг Ногоон барилгын шинэ технологи нэвтрүүлж хүрээлэн буй орчныг хамгаалахад үнэтэй хувь нэмэр оруулсан.
2. Зэрлэг амьтны шилжилт хөдөлгөөний нэвтрүүлэх зорилгоор MNS6515:2015 стандартын шаардлагад нийцсэн гарцуудыг төлөвлөж хийсэн. Нийт төслийн хэмжээнд нүхэн гарц 11, нэг түвшний гарцийг 10 байршилд төлөвлөж өгсөн нь зэрлэг амьтан шилжилт хөдөлгөөн хийх боломжийг бүрдүүлсэн.
3. Төмөр замын өртөөний барилгуудын 70-80 хувь шилэн пасадаар баригдсан нь байгалийн гэрэлтүүлэг, дулааныг нэвтрүүлж цахилгаан эрчим хүчийг хэмнэж байна.

2.4. Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сум, Гашуунсухайт боомтод уул уурхайн бүтээгдэхүүнд түшиглэсэн холимог тээврийн терминал байгуулна.

Зорилтот түвшин: 2023 он: Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь

Биелэлт: 1. Ажлын талбайд олон салаа зам үүсгэхгүй байх зорилгоор маршрутын дагуу түр зам тавьж хөдөлгөөнийг зохицуулж байсан нь агаарын тоосонцор, хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ болсон.

1. Ашиглалт явуулсан болон хуучин ашиглаж нөхөн сэргээлт хийлгүй орхисон түгээмэл тархацтай ашигт малтмалын ордуудын нөхөн сэргээлтийг MNS5917:2008 стандартад

нийцүүлэн гүйцэтгэсэн. Нөхөн сэргээлтийг стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэж буй нь байгалийн аясаар сэргэн ургах нөхцөлийг бүрдүүлж байна. Нөхөн сэргээлтийн ажил 96.2 хувьтай байна.

- Төмөр замын анхны барилга угсралтын явцад үүссэн хаягдал шорооны овоолгуудыг бүрэн хэлбэржүүлж орон нутагт хүлээлгэн өгсөн.

Зүтгүүр, вагоны хувьд:

Төслийн хүрээнд нийлүүлэгдэх АНУ-аас орж ирэх шинэ 16 зүтгүүрийн хувьд /SD70ACe серийн/ зүтгүүр нь EPA утаа ялгаруулалтын стандартын дагуу баталгаажсан зүтгүүрийн хэвийн үйл ажиллагааны нөхцөлд утаа ялгаралтын хяналтын функцийг өөрчлөх эсвэл унтрааж болохгүй. 40 CFR §1068.101(1) нь утаа ялгаруулалтын зохицуулалтыг дагаж мөрдөхөд шаардлагатай төхөөрөмж, функцуудыг арилгах, ажиллахгүй болгохыг багтаасан хөндлөнгийн оролцоог хориглодог. Үүнд жишээлбэл, LEADER, хөдөлгүүрийг автоматаар асаах (AESS) гэх мэт эрчим хүч хэмнэх төхөөрөмжөөр тоноглогдсон зүтгүүрүүд болон бусад утаа ялгаруулалтыг хянах систем, зүтгүүрт санал болгож болох эрчим хүч хэмнэлтийн төхөөрөмж ордог. Мөн EMD зүтгүүрийн утааны хяналтын төхөөрөмж, системд засвар үйлчилгээ хийх, солих, засварлах ажлыг зүтгүүр, зүтгүүрийн хөдөлгүүр засварын байгууллага эсвэл хувь хүн гүйцэтгэж болдог зэргээр давуу талтай, байгаль орчинд ээлтэй. Сэлгээний /2GS16C/ зүтгүүр мөн АНУ-аас орж ирэх 1 ширхэг зүтгүүр нь хорт утааг маш бага ялгаруулдаг Shunter гээд төхөөрөмжтэй шийдэгдсэн онцлогтой.

3.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц:

| Эрх зүйн актын нэр | Зүйл, заалт | Хэрэгжилт (хувиар) | Үүнээс (хувиар) | | | | Хугацаа болоогүй |
|------------------------|-------------|--------------------|-----------------|----------|----------|----------|------------------|
| | | | 100 | 90 | 70 | 0 | |
| Засгийн газрын тогтоол | 3 | 93,3 | 1 | 2 | - | - | - |
| Дүн | 3 | 93,3 | 1 | 2 | - | - | - |

3.4. Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалын хэрэгжилт:

| Нийт заалт | Хэрэгжилтийн дундаж хувь | Үүнээс (хувиар) | | | | Хугацаа болоогүй |
|------------|--------------------------|-----------------|----|----|---|------------------|
| | | 100 | 70 | 30 | 0 | |
| 1 | 100.0 | 1 | - | - | - | - |

1.5. ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

| Нийт заалт | Хэрэгжилтийн дундаж хувь | Үүнээс (хувиар) | | | | Хугацаа болоогүй |
|------------|--------------------------|-----------------|----|----|---|------------------|
| | | 100 | 70 | 30 | 0 | |
| 3 | 100.0 | 3 | - | - | - | - |

1.6. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

| № | Мэдээллийн агуулга | Байршуулбал зохих мэдээллийн | Байршуулсан мэдээллийн төрөл | Тайлант хугацаанд байршуулсан (хувиар) | Хугацаа хоцроож байршуулсан (хувиар) | | | | | Хугацаа болоогүй (төргийн тоо) | Хэрэгжилтийн дундаж хувь |
|---|--------------------|------------------------------|------------------------------|--|--------------------------------------|----|----|----|----|--------------------------------|--------------------------|
| | | | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | | |
| | | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | | |

| | | | | | | | | | | | |
|---|--|----|----|----|---|---|---|---|---|----|-------------|
| 1 | Төсөв, гүйцэтгэл | 13 | 7 | 7 | - | - | - | - | 2 | 4 | 85.7 |
| 2 | Хөрөнгө оруулалт, тендэр, худалдан авалт | 6 | 4 | 4 | - | - | - | - | - | 2 | 100.0 |
| 3 | Бусад | 22 | 14 | 14 | - | 1 | - | - | | 7 | 93.3 |
| | Дүн | 41 | 25 | 25 | - | 1 | - | - | 2 | 13 | 93.0 |

Дөрөв. Дүгнэлт:

I. Төлөвлөлтийн байдал

1) “ТТЗ” ХХК 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын албанаас өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөхдөө хариуцах газар, хэлтсийн нэр заан тусгаж, яамтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшин, оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшнийг улирлаар хуваан яамны төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн.

II. Хэрэгжилтийн байдал:

1. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагааг гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 86.05% хувь, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 100%, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 93,3%, Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалын хэрэгжилт 100.0%, ТНДБ-ын тушаалын хэрэгжилт 100%, шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ 93% хувиар тус тус үнэлэгдсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **95,3** хувьтай байна

Тав. Санал, зөвлөмж

Цаашид:

- Компанийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт 1-ийн хүрээнд төлөвлөсөн Тавантолгой -Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлд тээвэрлэх ачааны хэмжээ гүйцэтгэгч компаниас нийлүүлэгдэх 16 зүтгүүр хойшилсоноос үүдэн биелэгдэх боломжгүй болсон тул анх төлөвлөсөн /2,4 сая.тн/ хэмжээнд хүртэл тээвэрлэх.
- Мөн төлөвлөгөөний 2.4-т заагдсан Гашуунсухайт-Ганцмод боомтын 7.9 км төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх арга хэмжээг эрчимжүүлэн ажиллах нь зүйтэй байна.

ТАНИЛЦСАН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.БУДБАЯР

ХЯНАСАН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА

Н.МӨНХСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ АУДИТОР

Ц.НУГАРМАА

2023.09.19